

**Монгол аман уламжлалаас оршуулгын соёлыг шинжлэх нь
(шороо болон хаданд оршоох ёсны тухай)**

*Индоржийн ДАВААДОРЖ**

*Монгол Улс, Улаанбаатар, Монгол Улсын Их Сургууль,
Шинжлэх Ухааны Сургууль, Хүмүүнлэгийн ухааны салбар,
Утга зохиол, урлаг судлалын тэнхим
Email: Davaadorj.i@num.edu.mn,
<https://orcid.org/0009-0005-0182-2983>*

Received: October 11, 2025 | **Accepted:** October 21, 2025 | **Published:** December 30, 2025

Хураангуй: Монголчуудын оршуулгын соёл, зан үйлийн гол хэсэг болох оршуулах ёс, хэлбэрийг угсаатны зүйн хээрийн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүн, монгол аман зохиолын жишээ баримтад түлгуурлан, монгол домог, бэлгэдэл зүйн нэгэн цогцолбор хэсэг болох таван махбод, өнгийн санаатай холбон авч үзлээ. Эл санаанд түшиглэн оршуулах ёс, хэлбэрийг шороо, гал, ус, мод, хад (төмөр)-д оршоох хэмээн ангилж, эл өгүүлэлд шороо болон хад (төмөр)-наа оршоох ёсыг задлан шинжилж, тайлан тайлбарлалаа.

Оршуулгын ёс, хэлбэрээс шороо, галд оршуулах ёс өнөөг хүртэл хадгалан үлдсэн бөгөөд шороонд оршуулах ёсыг Бурханы шашны дэлгэрэлттэй холбоотой түгсэн ил хөдөөлүүлэх ёстой зэрэгцэн оршиж байсныг аман мэдээнээс нотолж болно. Харин хад буюу төмөр махбодод оршуулах соёл нь шүтлэгийн уламжлалт хэлбэр, бөө мөргөлтэй холбогдож, нийгэм-түүх, шашин соёлын нөлөөгөөр оршуулгын бусад хэлбэрээр халагдан солигджээ. Үүний зэрэгцээ аман түүхнээ газар шинжих, гуйх зан үйлд ашиглах хэрэгслийг цөөнгүй дурдсан нь оршуулах соёл, зан үйлийн чухал хэсэг болохыг харуулж байна.

Түлхүүр үг: оршуулгын соёл, зан үйл, таван махбод, таван өнгө, аман түүх

* © И.Даваадорж, 2025

A study of Funerary Culture in Mongol Oral Tradition: Rituals of Inhumation and Rock Burial

DAVAADORJ Ishdorj

Department of Literature and Arts Studies,
Division of Humanities, School of Arts and
Sciences, National University of Mongolia
Ulaanbaatar, Mongolia

Abstract: *This paper explores core aspects of Mongol funerary culture, focusing specifically on burial rituals and forms. The analysis draws on ethnographic fieldwork, primary source materials, and examples from Mongol folklore. We examine these rituals through the lens of the five elements (earth, fire, water, wood, and rock/metal), which form a cohesive symbolic system within Mongol mythology and symbology. Using this framework, we categorize burial types according to their associated elements. This article provides an in-depth analysis of earth and rock (metal) burial traditions. Among these various forms, earth and fire burials have survived to the present day. According to oral accounts, earth burial spread alongside the rise of Buddhism and often coexisted with sky burial (the practice of open-air exposure burials) practices. By contrast, rock or metal-related burial customs reflect older belief systems rooted in shamanism. These older practices were gradually replaced due to socio-historical and religious transformations. Oral histories frequently describe associated rituals-such as land divination and the use of specialized tools-underscoring their integral role within the broader funerary system.*

Keywords: *funerary culture, rituals, five elements, five colors, oral history*

Удиртгал

Монголчуудын оршуулгын зан үйл, соёлыг түүх, археологи, угсаатны зүй зэрэг салбарын эрдэмтэд судалж, олон арван бүтээл туурвисан байна. Археологийн ихэнх малтлага, судалгаа нь оршуулгын соёл, зан үйлтэй нарийн нягт холбогдох учир тэдгээр бүх судалгааг энд дурдах боломжгүй. Тиймийн учир оршуулгын зан үйл, оршуулах ёс, хэлбэрийг угсаатны зүй, аман зохиолын өнцгөөс судалсан бүтээлийг дурдвал “БНМАУ-ын Угсаатны зүй” I (1987), “Монгол Улсын Угсаатны зүй” (1996) хамтын бүтээлд монголын зарим угсаатны бүлгийн оршуулгын соёлыг хээрийн судалгааны материалд тулгуурлан бичжээ. Мөн эл зан үйл, соёлын тухай цөөнгүй бүтээл хэвлэгдсэнээс жишээлэн дурдвал Х.Пэрлээ (1956), Ч.Далай (1959), Х.Нямбуу (1976, 1984), Ч.Аръяасүрэн, Х.Нямбуу (1991), С.Бадамхатан (1995, 2004), О.Пүрэв (1998), Д.Эрдэнэбаатар (2001), А.Пунсаг (2003, 2011, 2012, 2019) Г.Батнасан (2006), Б.Бадам-Оюу (2005), Г.Пүрэв-Очир (2006), Ц.Баасандорж (2018), Б.Хишигсүх, Б.Риза (2018, 2019), Ц.Аюуш (2019), Г.Бямбарагчаа (2019), Г.Гантогтох (2019), А.Жамбал (2019), Э.Жигмэддорж (2019), Д.Тангад (2019), С.Өлзийбаяр (2023), Б.Лхагвадорж, Б.Отгонбаяр (2023), Н.Маралмаа (2023), О.Болормаа (2023), У.Пүрэвжав (2024) нарыг дурдаж болно. Монголчуудын уламжлалт болон орчин үеийн оршуулах ёсны тухай Г.Батнасан

(2005), Б.Отгонбаатар (2009), Г.Идэрмаа (2023) нар нэгэн сэдэвт зохиол туурвижээ. Тэнгэр болоочийг оршуулах зан үйл, шат дарааллын тухай Бүрэнтөгсийн голлон найруулсан “Монгол зан үйлийн нэвтэрхий толь”-ийн Оюуны боть (1999), С.Дуламын “Монгол соёлын тайлбар толь бичиг” (2024)-г дэлгэрэнгүй бичсэн байна.

Мөн монголчуудын оршуулгын соёл, зан үйлийг гадаадын эрдэмтдээс анхлан Монгол нутгаар аялсан өрнийн жуулчид алсалмал хараагаар тэмдэглэн үлдээжээ. Археологийн дурсгал, шүтлэг мөргөл, соёлын өөрчлөлтийн талаар В.В.Бартольд (1966), Н.Я.Жуковская (1977), П.Серен (2004), О.П.Рыкин (2007), Фужи Мако (2008) зэрэг судлаачид шинжлэн судалсан байна.

Энэхүү сэдвийн талаар БНХАУ-ын эрдэмтэн Намжилдорж (1984), Бөххад (1992), Сэцэнбилиг (1993), Лхамсүрэн (1994), Баатар (2001), Хурцбилиг (2002), Үсрэнгүй (2007) нарын бүтээл буй юм. Эдгээр эрдэм шинжилгээний бүтээлээс Хурцбилиг (2002) “Монголчуудын оршуулгын соёл” бүтээлд монголчуудын оршуулгын өмнөх бэлтгэл, оршуулга хийх бодитой зан үйл, оршуулга хийсний дараах хийх ажлыг түүх, угсаатны зүй, аман зохиолын мэдээ баримтад түшиглэн цогц шинжлэн үзсэн нь ач холбогдолтой байна.

Эл өгүүлэлд урьд өмнөх судалгаа, эрдэм судлалын ажилд тулгуурлан, монголчуудын оршуулгын соёл, зан үйлийн оршуулах ёс, хэлбэрээс шороо болон хаданд оршоох зан үйлийг сонгон авч, аман зохиол, хээрийн шинжилгээ, судалгааны эх хэрэглэгдэхүүн, түүх, археологийн баримтад тулгуурлан, задлан шинжилж, тайлан тайлбарлах (*interpretation*)-ыг зорилоо.

Судалгааны хэсэг

Наснаас нөгчигсдийн цогцос ясыг гэр орноос нь гаргаж, урьдаас тогтсон газарт нь залж аваачаад, ямар нэгэн арга хэлбэрээр нутаглуулах, бэлэвсрэн гашуудах заншил ёслолыг оршуулга гэнэ (Дулам, 2024: 614). Амьсгал хураасан нэгнийг оршуулах зан үйл нь сүсэг бишрэл, бэлгэдэл болон практик үйл ажиллагаа хосолсон, энэ ертөнцийнхөн болон жир хүнд үл хүртэгдэх ертөнцийнхөнд зориулсан цогц зан үйл юм. Энэ ертөнцөөс харьсан хүмүүнд зориулсан зан үйлийг оршуулгын өмнөх, оршуулгын үеийн, оршуулгын дараах хэмээн ангилан үзэж болох агаад эл өгүүлэлд оршуулгын үеийн зан үйл, оршуулгын ёс, хэлбэрийг тухайлан авч үзлээ.

“Монгол зан үйлийн нэвтэрхий толь”-ийн II дэвтэр Оюуны ботид монголчуудын оршуулгын ёсыг “шороонд оршуулах, усанд оршуулах, галд оршуулах, сул оршуулах, салхинд хатаах зэрэг хэдэн их төрөлд хуваадаг” (Bürintegüs II, 1999: 189) хэмээн тэмдэглэсэн байна. Мөн профессор С.Дулам “Монгол соёлын тайлбар толь бичиг”-т монголчуудын оршуулгын арга хэлбэр нь эрт үедээ шороо, гал, ус, мод, хад (төмөр) гэсэн таван махбодын аль нэг хэлбэрээр оршуулдаг заншилтай байснаас бидний үед ил хөдөөлүүлэх болон газар шороонд оршуулах хэлбэр уламжилсан хэмээжээ (Дулам, 2024: 615).

Монгол утга соёлд өнгийг дан дангаар авч үзэн, бэлгэдэлт утгыг тодруулж болох ч домог зүйн үндэст тулгуурлан таван өнгө, таван зүгийг хослуулсан нэгдмэл цогцолбор байдлаар үздэг нь оршуулгын соёлтой холбогдож байна. Эл таван өнгө, зүгийн нийлбэр цогц нь Хорчин монголчуудын дунд уламжилсан

“Галавын үлгэр”, говийн халхчуудын “Үзлэг гарсан нь” хэмээх домог зүйн бичвэрт уламжилжээ.

Профессор С.Дулам 1977 оны 5-р сарын 13-ны өдөр Жирмийн чуулганы Сүргийн хошууны нутагт төрсөн Баярын Чунраа аругайгаас тэмдэглэж авсан “Галавын үлгэр”-г ертөнцийн үүсэл болон таван махбод, өнгө, зүг чигийг тодруулах өгүүлэмж буй юм. Эл домог зүйн бичвэрт галавын эзэн бүтээгч баатар Шагжамуни Хурмаст тэнгэрийн хэлсэн ёсоор газрыг бүтээхээр нэлий их усанд бөөрөнхий шар шороог хаядаг. Ийн хаятал Матар мэлхий өнөөх шороог элгэндээ тэвэрч үл салахад, бүтээгч баатар Шагжамуни Матар мэлхийг харвадаг.

Тэгсэн мэлхийн хойшоо хандаж байсан толгой нь урагшаа хандаж, бөгс нь хойшоо эргээд амнаас нь гал гараад, бөгснөөс нь шээс гараад үхэж гэнэ. Иймд баруун талаас нь харвасан сум мөн төмөр зэвээрээ баруун тийшээ хараад унасан тул, модон иш нь зүүн тийшээ харж, зүүн зүгийг хөх модон зүг, баруун зүгийг цагаан төмөр зүг, хойд зүгийг хар усан зүг, урд зүгийг улаан гал зүг гэж нэрлэсэн учиртай юм гэнэ. Элгэндээ тэвэрч байсан шар шороо нь төв дунд мандсаны учир шар шороон зүг болжээ (Dulam., Vasek, 2013 [1983]: 14).

Бүтээгч баатар ертөнцийн эхэн газрын өрийг бүтээснээс үүдэн таван махбод, таван өнгө, зүг чигийн цогц үүссэн байна. Дээрх домгоос харвал зүүн зүгийг хөх модон зүг, баруун зүгийг цагаан төмөр зүг, хойд зүгийг хар усан зүг, урд зүгийг гал улаан зүг, төв дундыг шар шороон зүг хэмээн нэрлэх болсон агаад гэр өргөө, тоглоом наадгай, гар урлал, цэрэг цуух мордох зэрэг монгол соёл иргэншлийн бүхий л хэсэгт тусгалаа олжээ (Дулам, 2020 [2000]: 57-58).

Бид энэхүү санааг түшиглэн монгол домог, бэлгэдэл зүйн таван махбод, түүний дотор шороо болон төмөр (хад) махбодод оршуулж байсан уламжлалыг түүх археологи, аман зохиол, угсаатны зүйн хээрийн судалгааны материалд тулгуурлан тодруулах юм.

Шороонд (газарт) оршуулах ёс

Оршуулгын ёс, хэлбэрээс хамгийн түгээмэл тархсан нь шороонд оршуулах ёс юм. Археологийн судалгааны үр дүнгээс ажвал шороонд оршоож, булшлах ёс, зан үйл нь чулуун зэвсгийн үеэс эхэлжээ. Дунд палеолитын үед амьдарч байсан неандерталь (*Homo Neanderthalensis*)-ууд газарт булж оршуулдаг заншилтай байсныг Европ тивээс илэрсэн 20 гаруй археологийн дурсгал баталдаг (Цэрэндагва, 2019: 11). Харин манай улсаас олдсон хамгийн эртний оршуулгын дурсгал 34000-35000 жилийн өмнөх үед хамаарах Хэнтий аймгийн Норовлин сумын нутаг Салхит хэмээх газраас олдсон юм (Цэрэндагва, 2019: 11). Монгол нутагт оршиж байсан анхны төрт улс Хүннүгээс аваад түүхийн бүхий л хугацаанд шороонд оршоосон ихэс дээдэс хийгээд энгийн иргэдийн оршуулга бий агаад эдгээр соёлын дурсгал нь хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурь, хөрөнгө чинээ оршуулгын соёлд нөлөөлж байсныг баталдаг (Идэрмаа, 2023: 22).

ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачдын цуглуулсан угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүнд шороонд оршоох, булшлах ёстой холбоотой баримт арвин бий юм.

Ц.Аюушийн “1978 онд Увс, Ховд аймагт ажилласан угсаатны зүйн хээрийн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүн”-д Ховд аймгийн Манхан сумын 4-р бригадын хоньчин Г.Содном (52 настай, эрэгтэй, захчин) ийн мэдээлжээ.

Манай сум 4 бригад, мөн сумын дэргэд оршуулгын газартай. Оршуулга гэдэг нэр сайн нэвтрээгүй байна. Одоогоос ингэж ярих болж байна. Гээх гэж ярилцдаг байсан, энэ үгээр ярьж байна. Газар тус бүр нь гадуураа хүрээ гортигтой. Модон авсанд хийж гээж байна, амьдадаа өмсөж байсан хамгийн сайхан хувцсыг өмсгөж байна. Мөн авсанд нь цай, архи, чихэр, үзэм, ногоон цай, халуун савтай цай хийгээд хаддаг. Бас цаг, үзэг хийдэг. Шарил гэрт байхад бүх юмыг хийгээд хадаж байна. Газар дээр очоод хадах ч байна. Шарил хөнгөлөх, шарил шуух гэж ярьж байв. Энэ нь нас барсан хүний биеийг (цогцсыг) хурааж жижижхэн болгохыг хэлж байлаа. Одоо ч биеийг янзалж, хувцсыг сольж өмсгөхийг ингэж ярьдаг. Авсанд хийж байгаа болохоор хоёр гарыг биеийн дагууд нь тавьж, гэдрэг харуулаад шулуун болгоод засаж янзалж байна (МУЗХСЭХ IV, 2011: 247).

Уг аман түүхээс ажвал оршуулгын ёс, заншилтай холбогдох ойлголт, нэр томьёо хэрхэн хувирч буйг тодорхой өгүүлжээ. Тухайн сум, бүс нутагт амьдарч байсан иргэдийн дунд “гээх” хэмээн нэрлэж байсан ойлголт хувиран өөрчлөгдөж, “оршуулах” нэр томьёогоор солигдож буй соёлын үг хэллэгийн өөрчлөлтийг харж болох юм. Мөн тэнгэр бологчийн бие цогцсыг оршуулгад бэлтгэн, янзлахыг “шарил хөнгөлөх, шарил суух” хэмээн нэрлэж, идээ ундаатай холбоотой эдлэл хэрэгсэл, соёлын зүйлсийг дагуулж байна.

Мөн угсаатны зүйн хээрийн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүнээс ажиглан үзвэл ил хөдөөлүүлэх болон газар шороонд оршуулах ёс, хэлбэрийг зэрэгцэн үйлдэж, халж сольж байсныг ажиглаж болно. Угсаатны зүйч Г.Цэрэнхандын “1983 онд Дундговь, Дорноговь, Өмнөговь аймагт ажилласан угсаатны зүйн хээрийн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүн”-д Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын Говийн хөгжил, Могойт бригадын Сугарын Батжав (82 настай, эрэгтэй) ийн мэдээлжээ.

Довын хонхор газар эргэн тойрон гүвээгээр хүрээлэгдсэн, ам нь нар луу, өмнө баруун өмнө зүгт харсан дугуй хонхор газарт оронгын эврээр хөндлөн зурна. 1950-аад оноос булах болов. Хууччуулын газарт заавал хүргэх ба өдөржин явах, зуур хонож очих ч газар байна (МУЗХСЭХ VII, 2011: 285-286).

Дээрх аман мэдээнд 1950-аад оноос хойш газар газарт булж оршуулах ёс, хэлбэр дахин хэвшсэнийг мэдээлжээ. Мөн судлаач И.Лхагвасүрэн “1989 оны 1, 2 сард Баян-Өлгий аймгийн Булган, Сагсай сумдад ажилласан угсаатны зүйн хээрийн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүн”-д “Сэнхэрийн нутагт ил тавьдаг гээд бага хүрээнийхэн их дургүй байдаг. Манай Булган голд талийгаач болсон хүнийг заавал булж оршуулдаг байсан” (Хоохойн Халзай, 75 настай, Түнхэн элкэн) (МУЗХСЭХ X, 2011: 199) хэмээсэн нь эл оршуулах хоёр хэлбэр тодорхой он цагийг заалгүй зэрэгцэн байсныг батлах юм. Үүний зэрэгцээ Увс аймгийн Малчин сумын 1-р бригадын хоньчин Г.Баглаа (68 настай, эмэгтэй, долоон баяд)-н аман мэдээнээс цаг улирал, газрын шинж байдлаас хамааран ялгаатай ёс, хэлбэрээр оршуулж байжээ.

Эцгийг ил тавив, ээжийг булж оршуулав. Гэхдээ авсанд хийгээгүй. Одоо манайхан сумын газарт авчирч оршуулах ховор байна. Бид сумын захиргаанд хэлдэггүй, биднийг үйлчлэхгүй байна. Одоо авсанд хийлгүй, газарт нь булчхаад байна. Ил тавих нь хааяа үзэгдэж байна. Ялангуяа өвлийн цагт их тохиолдож байна (Ц.Аюуш “1978 онд Увс, Ховд аймагт ажилласан угсаатны зүйн хээрийн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүн”) (МУЗХСЭХ IV, 2011: 318).

Ил хөдөөлүүлэх болон шоронд оршуулах ёс, хэлбэрийг цаг улирал, газрын байдлаас хамааран сонгож байсныг дээрх аман түүхээр нотолж болно. Мөн шороонд оршоох хэлбэрт засаг захиргааны тодорхой нэгж оролцохгүй байгаагаар нийгэм, улс төрийн өөрчлөлт, шийдвэр хувь хүний аж төрөл амьдралд хэрхэн нөлөөлж буйг үзүүлдэг аман түүхийн нэгэн онцлог шинж илэрч буй юм (Нандинбилиг, Дулам. 2020: 236-243).

Судлаач И.Лхагвасүрэнгийн “1989 оны 1, 2 сард Баян-Өлгий аймгийн Булган, Сагсай сумдад ажилласан угсаатны зүйн хээрийн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүн”-д нас болсон хүнийг оршуулах үеийн зан үйлийг тодорхой тэмдэглэсэн байна.

Сүрэнгийн Шилэг 69 настай. Баруун амбаны Цэрвээ сум, Элкэнээ мэдэхгүй.

Талийгаачийн толгойг заавал урд зүг рүү харуулдаг байжээ. Гэрт хэвтэж байсан байдлаар нь тавина. Дээрээс нь маш их арц хийнэ. Толгой дор нь цагаан чулуу тавина. Тариа цацахдаа мөн идээний дээжийг хамт хийнэ. Эхлээд хань ижил нь эсвэл үр хүүхэд нь шороо хийнэ. Тэгээд бүх хүн шороо хийнэ. Лам хүн ойролцоо суугаад номоо уншина. Талийгаачийн толгой дээр мөн сан тавина. Мөн бичсэн маанийг модонд бэхлээд хатгана. Газартай шороог тэгшлээд дээрээс нь сүү идээ сацна (МУЗХСЭХ X, 2011: 168).

Эл аман мэдээнд бүрлээчийн биеийг зассан хэлбэрээр гуйж авсан газар бэлтгэсэн нүхэнд байрлуулж, шороо хийн бунхлах дарааллыг тоочин өгүүлсэн байна. Мөн ил хөдөөлүүлэхэд цагаан чулуу дэрлүүлж, хөх чулуу өшиглүүлдэг ёсыг хувирган уламжилж, шороонд оршоохдоо цагаан чулуу дэрлүүлж буй юм.

Угсаатны зүйн хээрийн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүнд шороонд оршуулах болон ил тавьж, хөдөөлүүлэх ёс холбоотойгоор түгээмэл дурдаж буй зан үйл бол газар авах юм. Бүрлээчийг оршуулах газрыг шинж авах, сайн бэлгэ шинжтэй газар оршуулах нь талийгчаас гадна үлдэн хоцорч буй гэр бүл, садан төрлийн аж амьдралд чухал нөлөөтэй хэмээн үзэх итгэл бишрэлд уг ёс тулгуурлаж байна. Эл санааг Ховд аймгийн Мөнххайрхан сумын иргэн, дархад арваны эмчийн элкен Тариачийн Нанзад (69 настай, эрэгтэй) “Эцэг хүнийг оршуулах газрыг маш сайн сонгодог. Эцгийг оршуулбал хүү сайн явна гэж үздэг” (МУЗХСЭХ X, 2011: 54) хэмээнээс тодорхой харж болно. Мөн Т.Нанзад “Хүүхдийг цэвэрхэн газар гээх журмаар оршуулдаг. Газар авдаггүй” гэснээс нас бологчийг оршуулах газрыг сонгохдоо нас, хүйс зэргийг харгалзан үздэгийг тодорхой мэдээлжээ.

Газар авахад тухайн энгэр ээвэр, уулийн онь таарсан эсэх газар орны байц шинжийг харгалзахын зэрэгцээ шорооны шинж чанарыг шинжлэн үздэг. Газрыг шинжихдээ “Хүн оршуулах газар улаан шороотой байвал сайн гэдэг. Улаан шороотой газрыг бурхны шороотой газар гэж ярьдаг байсан. Хар шороотой газрыг шуламсын орон гэж ярьдаг байсан” (Ж.Дүгэр) (МУЗХСЭХ X, 2011: 249)

хэмээнээс улаан бор хийгээд хар өнгөөр шорооны шинжийг ялган, бүрлээчийг оршуулах газрыг сонгож байгааг харж болно. Мөн шороог алив зүйлд тогтон наалдах байдлаар шинжлэн, “Хүн оршуулах тосон шороотой газар байх ёстой. Үнсэн шороотой газар болохгүй. Тэр газрын шороог хувцсандаа наагаад гөвөхөд арилбал тосон шороотой, гарахгүй бол үнсэн шороотой гэж үздэг. Галт уулын харууссан газар хүн тавихгүй (галтын харуустай газар)” (Гариачийн Нанзад, 69 настай, эрэгтэй) (МУЗХСЭХ Х, 2011: 225) хэмээн шорооны ширхэг, тогтох чанар, физик газар зүйн байдлыг чанд харгалзан үздэг буй юм.

Нас болоочийг оршуулах газрыг тухайн нутаг орны байц харууц, шорооны чанар зэргийг шинжлэн мэдсэний дараагаар тодорхой бэлгэдэлт утга бүхий эд зүйл, эдлэл хэрэглэлээр зурж, гуйдаг. Аман түүхэнд оронгын эвэр, гахайн соёо зэрэг ан амьтны эвэр, соёог түгээмэл дурдсан байна. Эл учрыг судлаач Т.Дисаны “1981 онд Төв, Өвөрхангай, Булган аймгуудад ажилласан хээрийн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүн”-ээс тодруулбал, Булган аймгийн Бүрэгхангай сумын иргэн Зундуйн Аюур (57 настай, эрэгтэй) “Урьд догшин газраас мод авахдаа оронгын эврээр газрыг нь сэндэлж байж авна (зурна). Лус хавьтахгүй гэнэ. Авах модоо тойруулан зурна... Мөн оронгын эврээр хүн оршуулахад газрыг нь эвгүй бол зурж байж оршуулна” (МУЗХСЭХ VI, 2011: 83) хэмээн мэдээлжээ. Мөн Ховд аймгийн Алтай сумын иргэн, захчин Монцойн Үржин (58 настай):

Морь эвшээх, нуруугаа шилгээх, шээх зэргийг их бэлгэцшээж тэр газар хүний шарилыг тавьдаг байсан. Газрыг оронгын эврээр авдаг байсан. Газрын сүлдийг зайлуулах гэж оронгын эврээр газар зурдаг байсан. Одоо ч гэсэн захчин хөгшичүүд газар зурж тоглохыг их цээрлэж хориглодог (МУЗХСЭХ VIII, 2011: 200).

Газрыг оронгын эвэр, гахайн соёо зэрэг бэлгэдэлт эд зүйлээр хөндөх нь газрын амь гарна, газрын сүлдийг зайлуулна хэмээн газар орны эзэн, лусад хандсан зан үйл болох юм. Тэнгэр бологчид зориулан газар гуйхдаа оронго, тэхийн эвэр, гахайн соёо ашиглаж байсныг доорх аман мэдээнд тодорхой өгүүлсэн байна. (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Газар гуйх тухай угсаатны зүйн тайлан, эх хэрэглэгдэхүүн

№	Тайлан, эх хэрэглэгдэхүүн	Аман мэдээ
1	Г.Мэнэс “1986 онд Ховд аймгийн Манхан суманд ажилласан угсаатны зүйн хээрийн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүн” Ховд аймгийн Алтай сумын иргэн, Харнууд элкен Жаргалын Дүгэр (86 настай, босоо дэгрээ тамгатай)	<i>Морь шээсэн, эвшээсэн, шилгээсэн газрыг эрхэмлэн хүн тавих газар болгон сонгож авдаг байсан. Газар авахдаа оронгын эвэр, гахайн соёо, тэхийн эврээр зурж авдаг байсан. Хонины арьс дэвсэж авдаг байсан гэдэг (МУЗХСЭХ VIII, 2011: 200).</i>

2	<p>Г.Мэнэс “1986 онд Ховд аймгийн Манхан суманд ажилласан угсаатны зүйн хээрийн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүн”</p> <p>Ховд аймгийн Мөнххайрхан сумын 2-бригадын иргэн, Жанавагда элкен Налгарын Бат-Өлзий (87 настай, эрэгтэй, чагттай хөхүүр тамгатай)</p>	<p><i>Энд бол хүйс нас хамаагүй оршуулах газр сонгоод хүн тавих газраа төрлийн нэг х гахайн соёо, оронгын эвэр, модоор зур авдаг байсан. Зурсны дараа “алта дэвсгэр авлаа” гэж хэлдэг байсан. Дар нь тариа будаа цацдаг, хадаг тавьд байсан (МУЗХСЭХ VIII, 2011: 203).</i></p>
3	<p>Г.Мэнэс “1989 онд Ховд аймгийн Захчин нарын дунд ажилласан угсаатны зүйн хээрийн судалгааны тайлан эх хэрэглэгдэхүүн”</p> <p>Ховд аймгийн Мөнххайрхан сумын иргэн, дархад арваны эмчийн элкен Тариачийн Нанзад (69 настай, эрэгтэй)</p>	<p><i>Болно гэсэн газраа оронгын эврээр эсвэл ташуурын ишээр хүний хэмжээгээр дөрвөлжин газар зураад авдаг. Тэр дөрвөлжиний өр газар жижиг цагаан давуу дэвсэнэ. Түүнийгээ чулуугаар дардаг ёстой. Тэгээд сонгосон газраа сүү, тариа будаа цацдаг. Газраа зурахад эсвэл газрын хөрс хөдөлгөхөд газрын амь гардаг гэдэг (МУЗХСЭХ X, 2011: 225).</i></p>

Газар усны эзэн, навдаг, шавдгаас талийгчийг нутаглуулах зөвшөөрөл авч буй уг газар гуйх, газар авах, газар сацах хэмээн ялгаатайгаар нэрлэх эл зан үйлд оронгын эврийг түгээмэл ашиглахын зэрэгцээ бусад ан амьтны эвэр, соёо, малын тоног хэрэгслээс ташуур болон ирт багажаар зурж авдаг ёс буй юм (Дулам, 2024: 626).

Газар гуйх, авахад түгээмэл ашиглаж буй оронгын эврийн утга тайлал нь бөө мөргөл болон Бурханы шашинтай холбогддог. Оронгын эвэр нь монгол аман соёлын халхлагч таван эрдэнийн нэг юм. Амьтны таван чадлын нэг гайхалтай жишээ бол хон хэрээний сод, лаг мэлхийн цар, сог зарааны өргөс, оронгын эвэр, бодон гахайн соёог монгол хүн “халхлагч таван эрдэнэ” гэдэг (Bürintegüis II, 1999, 235). Энэ бол “оргойтой бөөгийн жатга, орхимжтой ламын хараал” сайн муугийн хорлол бүхнээс авран хамгаалдаг ид шидтэй зүйлс болно (Дулам, 2024: 888-889). Элдэв хараал ширээл, хатуу хэцүүгээс хамгаалагч, халхлагч таван эрдэнийн нэгийг өөд бологчийг оршоох газар гуйхад ашиглаж, лус, газар орны эзэн, сүлдийг бүрлээчид үл хавьтуулах, зайлуулахаар ашиглаж буй юм.

Мөн газар гуйхад оронгын эвэр хэрэглэх ёс Монгол орноо өргөн дэлгэрснийг доорх Бурхны шашны дүр, өгүүлэмж бүхий бичвэрт өгүүлсэн байна.

Анх Бурхан багш өмнөд Энэтхэгийн Гандаригуд буюу Тас цогцолсон нэрт ууланд олон шавь нарт ном номлож ахуй цагтаа хийд орон барихаар болжээ. Ингэхдээ шавь Гунгаавуудаа газарт тиг гортиг татахыг үүрэг болгожээ. Гунгаавуу газарт зурж байснаа зогсоод инээж гэнэ. Бурхан багш “Гунгаавуу юунд инээв” хэмээн асуухад “Энд бид таны шавь нарын суух орон хийдийн тиг гортигийг татаж байхад дээд тэнгэрийн оронд таны шавь нарын суух орон суурины тигийг мөн татаж байхыг мэдсэний учир инээв” хэмээн хэлсэн байдаг. Энэ газар дэлхий дээр газар хөндөж, орон суурин барьсны шалтгаан бэлгэ чанарыг үзэхэд хойно энэ нь урт удаан орших хийгээд буянт сайн үйлийн

шалтгаан нөхцөл болгохын тул оронго гөрөөсний эврийг хэрэглэх болжээ. Тэр утгаар газар шинжихэд оронго гөрөөсний эврийг өргөн хэрэглэдэг бөгөөд Монгол газар ихэд дэлгэрчээ (ГШМС I, 2015: 9).

Нас болоочийг оршуулах газрыг гуйх, авахад түгээмэл хэрэглэж буй оронгын эврийн талаар өгүүлэх хоёр баримтаас ажвал нэгэн талаас монгол утга соёлд элдэв хатуу үйл, хорлолоос хамгаалах оронгын эвэр, гахайн соёо зэргийг ашиглан, газар орны эзэн, лусыг аргадан авах, газрын сүлдийг зайлуулан, лус ханцан оршихоос сэргийлэх зан үйлийн утга илэрч буй бол нөгөө талаас буян сайн үйл дэлгэрэх шалтгаан нөхцөлийг харгалзан үзэж, оронгын эвэр ашиглаж буй юм.

Хад (төмөр)-д оршуулах ёс

Өнөөгийн байдлаар Монгол Улсын нутагт 130 гаруй хадны оршуулга бүртгэгдсэн агаад эл оршуулах ёс нь НТ III-XVII зуун хүртэлх хугацаанд Алтай, Хангай, Хэнтий нуруу, говийн уулсаар нэлээн өргөн дэлгэрсэн оршуулгын нэгэн төрөл болж байв (Хүрэлсүх, 2019: 112). Эл ёсны тархац, “оршуулгын соёлын эх үүсвэр Алтайн нурууны бүс нутагт тавигдаж, энэхүү бүс нутагтаа мянга гаруй жил үргэлжилжээ. Эндээс зүүн тийш Монгол орны Төвийн бүс буюу Хангайн нуруу руу тархсан. Төвийн бүсээс илэрч гарсан оршуулгын ихэнх нь Кидан болон Монголын үед хамаардаг бөгөөд энэхүү соёлын нөлөө баруун зүгээс улбаалжээ” (Хүрэлсүх, 2024: 239). Түүхэн цаг үеийн хувьд Монгол орноо оршиж байсан эртний төрт улс болох Жужан, Түрэг, Уйгур, Кидан болон Монголын эзэнт гүрний үеийг хамаардаг.

Хаданд оршуулсан уулын байрлалыг авч үзвэл нийт оршуулгын 47 хувийг далайн түвшнээс дээш 1500 метрт байдаг нь нэгэн талаас тэнгэрийн уудам харагдах газрыг сонгож авсан, нөгөө талаас нөгөө ертөнцөд амар амгалан байх “газар орон” учир хүн, амьтны санаатай болон санамсаргүй нөлөөллөөс хамгаалсан хамгаалалт хэмээн үздэг (Хүрэлсүх, 2024: 59-61). Хадны оршуулга илэрсэн газрыг ангилж үзвэл:

- а. Багавтар агуй
- б. Хадны хөмөг
- в. Хадны хонгил, ангал, завсар
- г. Хадан нүх
- д. Хадны доорх хөндий зай
- е. Ханан хадны ёроол зэргийг ашигласан байдаг (Эрдэнэбат., Эрэглэн, 2001: 26).

1600 гаруй жил үргэлжилсэн уг оршуулах ёс, хэлбэр үүсэх болсон шалтгааныг нэгд, уул, хад чулуу ихтэй газар орны онцлог, хоёрт, Хүннүгийн үеийн оршуулгын нэгдмэл байсан систем задрах үйл явц, гуравт, оршуулга тоногдохоос сэргийлэх зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр үүсжээ хэмээн тайлбарладаг. III зуунд үүсэн бүрэлдэж, олонх дурсгал XIII-XIV зууны үед хамаарах эл оршуулах ёс XVII зууны үед Бурханы шашин дахин дэлгэрсэнтэй холбоотойгоор оршуулгын зан үйлд өөрчлөлт орж, “галийгаачийг оршуулахдаа газарт булшлах, агуй хаданд далд тавих хэлбэрийг аажим халж өөрчилсөн” (Хүрэлсүх, 2024: 272). Эрдэмтэн Г.Мэнэс, Л.Билэгт (2020) нарын “Хэрлэн голын саваас олдсон XII-XVI зууны нэгэн хадны оршуулгын тухай” өгүүлэлд энэхүү оршуулгын ёс, хэлбэрийг

угсаатны зүй, аман зохиолын мэдээ баримттай холбон тайлан тайлбарласан байна. 1986 оны хээрийн шинжилгээний үеэр Хэрлэн Баян-Улаан уулын Зүүн Баянбулаг амны Хүйтэн хошуу гэдэг газраас олдсон хадны оршуулгад "... цогцсыг эсгий дээр хэвтүүлэн, гэрийн ханан дээр тавьж ороон, хоёр үзүүрийг дээр нь зөрүүлсэн болох нь мэдэгдэв" (Бадамхатан., Мэнэс., Билэгт. 2020: 86) хэмээн тэмдэглэжээ. Эл өгүүлэлд хаданд оршуулах ёсыг "Аламж мэргэн хүү, Агуйн Гохон дүүхэй" буриад туульд буй

Алтайн цагаан хад онгой
Хайрт ахаа оршуулах минь!
Хүхүйн улаан хад ганх
Хайрт ахаа оршуулах минь, би!

гэх өгүүлэмжтэй холбон тайлбарласан байна. "Ханат гэрээс хадан гэрт харих" хэмээх аман хэвшлээр тодорхойлж болох оршуулах ёс, хэлбэрийг "Айдурай мэргэн" буриад туулиас мөн харж болно.

Анга улаан хадын
Орой дээр нь гараад л
"Анга улаан хад минь"
Ангас хийж өгөөч.
Ахынхаа цагаан ясыг
Авах ёстой боллоо"

гэж хэлэн байв гэнэ.

Анга улаан хадын гэлээ
Орой дээр нь гарч
Гурав дахин хурайлав.
Гурав дахин даллав.
"Ахынхаа цагаан ясыг

Авах ёстой боллоо...

Анга улаан хад
Ангас хийж өгөөч!
Ангас хийж өгөхөд нь
Ахынхаа ёсыг авч
Ангийн улаан хаданд
"Улаан хөлс чинь энэ!" гэж

Гурван есөн мөнгийг
Хавчуулж орхив гэнэ (АМ, 2009: 61-62).

Эл туульсын хэрэг явдал, өгүүлэмжээс хаданд оршуулах ёсны улбаа, уламжлалыг харж болох бөгөөд туульсын баатад, бодонгуудыг орон газар, дэлхийд үгийн шидээр хандан, нээх, удаагаар шившлэгийн тусаар эргэн сэргээх өгүүлэмж илэрч буй юм.

Энэхүү оршуулгын хэлбэрийг гурвын тооны бэлгэдэлтэй холбон үзэх боломжтой. Аргил цагаан өвгөн, Данихүрэл зэрэг монгол баатарлаг туульст аврагдах арга нь амархан заяаны бус үхэл, мултарч гарах нэн хэцүү заяаны үхлийн тухай өгүүлэн, монголчуудын үхлийн тухай үзэл сэтгэлгээг илэрхийлсэн байдаг (Дулам, 2020 [1999]: 69-70). Айдурай мэргэн туульд хаданд оршоон, эргэн

амилуулж буй нь заяаны бус, завсрын үхлийг илэрхийлж, эл оршуулгын хэлбэртэй холбогдох аман зохиолын нэгэн жишээ болж байна.

Хаданд оршоох ёсыг өнгө, зүг чиг хосолсон бэлгэдлийн тогтолцооны ёсоор цагаан төмөр махбодоор илэрхийлэх нь монгол домог зүй, домгийн сэтгэлгээтэй холбогдоно. Домог зүйн сэтгэлгээнд ан агнуур, элдэв зүйлсийг эсгэн зүсэх практик үйлдлээс улбаалан, гилбэр бүхий хад чулуу, задын чулуу зэрэгт “дотоод чадал” оршиж байна хэмээн үзэж, дүрийн эртний хэлбэрийн нэг цалиг дүр (фетиш) үүссэн (Дулам, 2020 [1989]: 34-37). Эл домог зүйн эртний дүрийн нэгэн хэлбэр домог, үлгэр, баатарлаг тууль зэрэг аман зохиолын төрөл зүйлд нөлөөлөн, туульсын баатар, унаа хүлэг болох морь хад чулуунаас тэсрэн гарах, хүйг хад чулуугаар таслах өгүүлэмж үүдсэн байна. Хадыг төмөр хэмээн үзэж, хадны оршуулгыг цагаан төмөр махбодод хандаж буй гэх тайлбарыг ирт мэс, жад, сум зэрэгт дийлдэшгүй баатар түүнээс хатуу, шид бүхий задын чулуу зэрэгт дийлдэж буйгаас ургуулан тайлбарлах боломжийг үүсгэдэг. Буриад туулийн баатар Абай Гэсэр Гал Дүлэн Мангасыг сум жадаар хөнөөж дийлэхгүй болохын цагт түүний ах Заса мэргэн “задай шулуугаар” шидэхэд аймшигт мангасыг онож үхүүлдэг (Уланов, 1969: 103) нь эл санааг батлах юм. Ер хад чулууг төмрөөс хатуу чанга, шид бүтээлтэй хэмээх эл домог зүйн сэтгэлгээний нэгэн ул мөрийг задын чулууг эртний домог зүйн харваач мэргэн баатар, аянга цахилгааны эзэн Хөхдэй мэргэний сум (Дулам, 2020 [1989]: 36) хэмээн дүрслэхээс ч ажиж болно.

Аман болон бичгийн зохиол, археологийн судалгаанд тулгуурлан цагаан төмөр махбод буюу хаданд оршуулах ёс, хэлбэрийн улбааг шинжлэн тодруулж болохын зэрэгцээ хээрийн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүн, аман түүхнээ хэрхэн тэмдэглэснийг авч үзэх нь чухал. Судлаач И.Лхагвасүрэнгийн “1988 онд Ховд аймгийн Мөнххайрхан, Дуут сумдад ажилласан угсаатны зүйн хээрийн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүн”-д Ховд аймгийн Дуут сумын иргэн Доокаан Донров (74 настай, эрэгтэй, Баруун бэйс, Мянгад сум, Хасаг арван, Халзан илгэн [галзад]) ийн мэдээлсэн байна.

Удган бөө байсан. Түүнийг тэмээний ясаар зураад (арьсыг) цусыг нь аманд нь хийгээд хамаг юмыг нь шатаагаад устгасан юм. Тэмээний ясаар арьсыг нь зураад цусыг нь амсуулахаар бөө бөөлж чадахаа больдог гэж ярьдаг. Цагаанхүү гэдэг самганы Чимэд бөөг хаданд оршуулсан гэж сонссон. Цагаанхүү самган одоо Ховдод байгаа (МУЗХСЭХ Х, 2011: 86).

Халх бөөг “Наян дархийн бөө” гэж нэрлэдэг. Энэ их номхон бөө байдаг. Урианхайн бөө нар их догшин бөө юм. Цэрэнхүү гэдэг нэртэй халх бөө байсан. Бөөг нас барахаар хаданд оршуулдаг байсан (МУЗХСЭХ, Х, 2011: 90).

Дээрх аман мэдээнээс үзвэл Ховд аймгийн Мөнххайрхан, Дуут сум буюу баруун монголчуудын дунд хаданд оршуулах ёс, хэлбэр нь шашин шүтлэгийн ялгамжааг харгалзан үзэх, тухайлбал бөө нэрийг оршуулах хэлбэр байсан нь тодорхой харагдана. Ховд аймгийн Манхан сумын иргэн Налгарын Бат-Өлзий “Их бөх, сайн мэргэн ламыг өндөр уулын орой дээр, элгэн талд ч гэсэн нэлээд өндөр газар тавьдаг байсан. Агуйд хүн оршуулж байгаагүй” (МУЗХСЭХ, VIII, 2011: 203) гэснээс энгийн иргэдийг оршуулахад төдий л дэлгэрээгүй ёс болох нь тодорхой харагдаж байна.

Эл оршуулгын ёс, хэлбэр нь бөө удганыг онголох ёстой холбогдох агаад хорь буриадын бөөгийн оршуулгад “чулуугаар дуганцаг гэр бариад, түүнийгээ модоор хучаад, навчаар даруулж, оргой амьтайг нь өмсгөж, цомцойлгон суулгаад, урд нь хэцийг нь түшүүлж, ташуурыг нь гарт нь углаад, хоёр царвуугаар нь газар тулган суулгаж оршуулдаг” (Гантогтох, 2019: 240) хороолж оршуулах ёсоор хоймсон баталж болно. Дээрх аман мэдээнд баруун Монголын захчин нарын дунд байгалийн бэлэн агуй хаданд бөөг оршоож буй бол хорь буриадын бөөг онголох ёсонд “хадан гэр”-г оршоож буй нийтлэг түгээмэл зүйл ажиглагдаж буй юм.

Эл хад чулуугаар гэр, хороо барьж оршуулах ёс дан ганц бөө нэрийг оршуулахад ашигладаг байсан бус цагаан яст тайж язгууртан нарт ч ийм хэлбэрийн тахилын байгууламж зориулан бүтээж байсныг угсаатны зүйч Д.Нансалмаагийн “1984 онд Дорнод, Хэнтий аймагт ажилласан угсаатны зүйн хээрийн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүн”-д “Ноён хатан хоёрыг оршуулахдаа чулуун гэр бунхан барьж, хувцас хунарыг нь өмсүүлээд гэрт ахуйд байдаг байдлаар нь суулгаж их эд хөрөнгө тавьдаг байсан гэдэг” (Дорнод аймгийн Сүмбэрийн САА-ийн төв Донойн Чимэд (60 настай, эмэгтэй, халх) (МУЗХСЭХ, VIII, 2011: 129) гэснээс харж болно.

НТ III-XVII зуунд Монгол Улсын Алтай, Хангай, Хэнтий нуруу, говийн уулсаар тархсан хаданд оршуулах ёсыг 1960-1989 онд тэмдэглэсэн угсаатны зүйн тайлан, эх хэрэглэгдэхүүнээс шүүн үзвэл зөвхөн нийгмийн нэг бүлэг, улс төр, шашны эрх мэдэл бүхий хэсгийг оршуулахад ашиглаж байжээ хэмээн урьдчилан дүгнэж болох юм.

Нөгөө талаас ийн хаданд оршуулах ёс өргөн тэмдэглэгдээгүй нь Төв халх зэрэг зарим угсаатны бүлэгт амиа тэвчих зэрэг “хатуу үхлээр буцсан хүнийг газар ухаж оршуулдаггүй, хад чулууны завсар хийх буюу уут авсанд нь төмөр хийж оршуулна. Тиймээс өөрийн үхлээр үхсэн талийгчийг оршуулахад биед болон авсанд төмөр зүйл хийхийг цээрлэнэ” (Дулам, 2024: 618) хэмээх ёстой холбогдох юм.

Дүгнэлт

Монголчуудын оршуулгын соёл, зан үйлийн нэгэн чухал хэсэг болох оршуулах ёс, хэлбэрийг аман зохиол болон угсаатны зүйн хээрийн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан шинжлэв. Ийн шинжлэхдээ монгол домог, бэлгэдэл зүйн нэгэн цогцолбор хэсэг болох таван махбод, өнгийн санааг түшиглэн, шороо болон хад (төмөр) махбодод оршуулах ёс, хэлбэрийг задлан шинжилж, тайлан тайлбарлалаа.

Эдгээр ёс, хэлбэрээс шороо, галд оршуулах ёс өнөөг хүртэл хадгалагдан үлдсэн бөгөөд шороонд оршуулах ёс нь Бурханы шашны дэлгэрэлттэй холбоотой түгсэн ил хөдөөлүүлэх ёстой зэрэгцэн оршиж, 1950-аад оноос шороонд оршоох ёс зонхилох болсныг 1960-1989 оны хооронд тэмдэглэсэн угсаатны зүйн хээрийн шинжилгээний тайлан, эх хэрэглэгдэхүүн, аман түүх нотолж байна. Газарт оршоох зан үйлд газар гуйх, авах, газрын сүрийг даран зайлуулж, бүрлээчийг лустай үл ханцахад бөө мөргөл болон Бурханы шашны бэлгэдэлт эд зүйл болох оронгын эвэр, гахайн соёог чухалчлан үзэж байна.

НТ III-XVII зуунд дэлгэрсэн хаданд оршуулах ёсыг аман түүхээс шинжлэн үзвэл, энгийн иргэдийн дунд төдий л дэлгэрэлгүй, нийгэм, улс төр, шашны эрх

мэдэл бүхий бүлгийг оршуулах зан үйл байсныг харж болно. Хаданд оршуулах ёсыг төмөр махбодод оршоож байна хэмээн үзэх нь монголчуудын домог зүйн сэтгэлгээ, дүрийн эртний хэлбэр дэх задын чулуу, туульсын баатар хад чулуунаас дэлбэрэн гарч ирэх өгүүлэмжээр нөхвөрлөн тайлбарлаж болох агаад монгол баатарлаг туульст хаданд оршуулах нь тухайн баатрын заяаны бус, завсрын үхлийг зааж буй юм. Хад буюу төмөр махбодод оршуулах соёл нь шүтлэгийн уламжлалт хэлбэр, бөө мөргөлтэй холбогдож, нийгэм-түүх, шашин соёлын нөлөөгөөр оршуулгын бусад хэлбэрээр халагдан солигджээ.

Угсаатны зүйн хээрийн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүнд буй аман мэдээнд тухайн цаг үед амьдарч байсан хүмүүс тухайн ёс заншилд хэрхэн хандаж, нийгэм – улс төрийн томоохон шийдвэр түүний дор буй хүмүүсийн амьдралд хэрхэн нөлөөлж байсныг олж харах боломжийг олгож буй юм.

Ном зүй

Айдурай мэргэн. (2009). Эмхэтгэн бэлтгэсэн Г.Гантогтох. Улаанбаатар: Бемби сан. [Aidurai mergen [Aidurai the Archer]. Emkhetgen beltgesen G.Gantogtokh. Ulaanbaatar: Bembi san. 2009.]

Гантогтох, Г. (2019). Хорь буриад бөөгийн оршуулга. *Монголчуудын хойлгийн зан үйл: уламжлал-орчин үе-чиг хандлага эрдэм шинжилгээний II хурлын материал.* 239-243. [Gantogtokh, G. The Burial Types of Khori Buriyat's Shamans. *Proceeding of Mongolian Funeral Rituals: Tradition, Modernity, Trends II*, 2019, 239-243.]

Газрын шинжийн монгол судар. Боть I. (2015). Mongolian Tibetology Series IV. Орчуулсан Б.Няммягмар. Улаанбаатар: Сод пресс. [Gazryn shinjiin mongol sudar [Mongolian Geomancy Sutra]. Vol. I. Mongolian Tibetology Series IV. Orchuulsan B.Nyammyagmar. Ulaanbaatar. Sod press. 2015.]

Dulam, S., Vacek, J. (2013). *A Mongolian mythological text.* Ulaanbaatar: Bitpress. First published: 1983. [Дулам, С. Вацек, Ж. Монгол домог зүйн бичвэр. Улаанбаатар: Битпресс. . Анхны хэвлэл: 1983. Dulam, S., Vacek, J. Mongol domog züin bichver. Ulaanbaatar: Bitpress. 2013. Ankhniï khevlel:1983.]

Дулам, С. (2020). *Монгол бэлгэдэл зүй. II боть: Өнгийн бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй.* Монгол соёлын чуулган. Боть IX. Улаанбаатар: Битпресс. Анхны хэвлэл: 2000. [Dulam, S. *Mongol belgedel züi. II boti: Öngiin belgedel züi, züg chigiin belgedel züi* [Mongol Symbolology. Vol. II: Symbolism of Color and Direction]. Mongol soyoliin chuulgan. Boti IX. Ulaanbaatar. Bitpress. 2020. Ankhny hevlel: 2000.]

Дулам, С. (2020). *Монгол домог зүйн дүр.* Улаанбаатар: Битпресс. Анхны хэвлэл: 1989. [Dulam, S. *Mongol domog züin дүр.* [The Characters of Mongol Mythology] Ulaanbaatar: Bitpress. 2020. Ankhniï khevlel: 1989.]

Дулам, С. (2024). *Монгол соёлын тайлбар толь бичиг.* Улаанбаатар: Нандир. [Dulam, S. *Mongol soyoliin tailbar toli bichig* [The Encyclopedia of Mongol Culture]. Ulaanbaatar: Nandir. 2024.]

Mongᠣl jaᠩ üyile-yin nebterkei toli II. Oyun-u boti. (1999). Būrintegüs ᠶoullan nayirayulba. Öbür mongᠣl-un sinjilekü uqayan teknig mergejil-ün keblel-ün qoriy-a (Būrintegüs II, 1999). [Mongol zan üiliin nevterkhii toli II [The

- Encyclopedia of Mongol Rituals. Vol. II]. Oyunii boti. Bүrentögs gollon nairuulav. Öbör Mongoliin shinjlekh ukhaanii tekhnik mergejliin khoroo. 1999].
- Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн** (МУЗХСЭХ). (2011). Боть I-X. Эрхэлсэн С.Чулуун., хянан нягталж, оршил бичсэн Г.Цэрэнханд, У.Булаг. Улаанбаатар: Соёмбо. [*Mongolyn ugsaatny züin kheeriin sudalgaany ekh khereglegdekhüün* [Field Reports in Mongolian Ethnology]. Boti I-X. Erkhelsen S.Chuluun, khyanan nyagtalj, orshil bichsen G.Tserenkhand, U.Bulag. Ulaanbaatar: Soyombo. 2010.]
- Идэрмаа, Г.** (2023). *Монголын төрөөс оршуулгын талаар баримталсан бодлого: Нийслэл хотын жишээн дээр*. Түүхийн ухааны доктор (PhD)-ын зэрэг горилсон диссертац. Улаанбаатар: МУИС-ийн Түүхийн тэнхим. [Idermaa, G. *Mongolyn törөөs орshuulgyn talaar barimtalsan bodlogo: Niisled khotyn jisheen deer* [State Policies on Burial Practices in Mongolia: On Example of the Capital City]. Ulaanbaatar: Department of History, NUM. 2023.]
- Мэнэс, Г., Билэгт, Л.** (2020). Хэрлэн голын саваас олдсон XII-XIV зууны нэгэн хадны оршуулгын тухай. in С.Бадамхатан, Г.Мэнэс, Л.Билэгт. *Монголчуудын гарал, үүслийн түүх: “Палеоэтнографийн экспедиц”-ийн хээрийн шинжилгээний эх хэрэглэгдэхүүн*. Улаанбаатар: Соёмбо. 86-88. [Menes, G., Bilegt, L. Kherlen goliin savaas oldson XII-XIV zuunii negen khadnii орshuulgiin tukhai. In S.Badamkhatan, G.Menes, L.Bilegt. *Mongolchuudiin гарал, үүслийн түүх: “Paleoethnografiiin ekspidits”-iin kheeriin шинжилgeenii ekh khereglegdekhüün* [The History of Mongolian Origins: Primary Field Sources from the Paleo-ethnographic Expedition] Ulaanbaatar: Soyombo. 2020. 86-88.]
- Нандинбилиг, Г., Дулам, С.** (2020). *Монгол аман зохиолын онол II: Хүүрнэн өгүүлэх аман зохиол, Жүжиг наадмын аман зохиол*. Улаанбаатар: МУИС Пресс. [Nandinbilig, G., Dulam, S. *Mongol aman zokhioliin onol II: Khüürnen өgüülekh aman zokhiol, жүжиг naadmiin aman zokhiol* [The Theory of Mongol Folklore II: Oral Narratives and Folk Drama]. Ulaanbaatar: MUIS Press. 2020.]
- Ойрадын баатарлаг туульс.** (1997). Эмхэтгэсэн Б.Дамиранжав, Д.Цэрэнсодном. Улаанбаатар: Т&U Printing. [*Oiradiin баатарлаг туулис* [The Heroic Epics of the Oirats]. Emkhetgesen B.Damiranjav, D.Tserensodnom. Ulaanbaatar: T&U Printing. 1997.]
- Отгонбаатар, О.** (2009). *Монголчуудын оршуулгын зан үйл*. Монголын угсаатны зүйн судалгаа. Боть I. Улаанбаатар: Мөнхийн үсэг. Анхны хэвлэл: 2009. [Otgonbaatar, O. *Mongolchuudiin орshuulgiin зан үйл* [Funerary Rituals of the Mongols]. Mongoliin ugsaatnii züin судалгаа. Boti I. Ulaanbaatar: Mönkhiin үсег. 2023. Ankhonii khevlel: 2009.]
- Уланов, А. И.** (1969). *Прекрасное в бурятских мифах*. –В кн.: Эстетические особенности фольклора. Отв. ред. Л.Е.Элиасов. Улан-Удэ: БИОН СО АН СССР. 101-112. [Ulanov, A. I. The Concept of Beauty in Buriat Myths. In *The Aesthetic Aspects of Folklore*. Eds. L.Ye.Eliasov. Ulan-Üde: Academy of Sciences. 1969. 101-112.]
- Хурцбилиг.** (2010). *Монголчуудын оршуулах зан үйлийн соёл*. Хөрвүүлсэн С.Даваабаяр. Улаанбаатар: Гэрэгэ Принтинг. Анхны хэвлэл: 2002. [Khurtsbilig. *Mongolchuudiin орshuulakh зан үйлийн соёл* [The Culture of Mongol

- Funerary Rites]. Khörvүүлсэн S.Davaabayar. Ulaanbaatar: Gerege Print. 2010. Ankhii khevel: 2002.]
- Хүрэлсүх, С.** (2019). Монголчуудын оршуулгын нэгэн төрөл болох хадны оршуулгын зан үйл. *Монголчуудын хойлгын зан үйл: уламжлал-орчин үе-чиг хандлага эрдэм шинжилгээний II хурлын материал*. 105-114. [Khürelsükh, S. Rituals of Rock Burial: A Form of Mongolian Funerary Practices. *Proceeding of Mongolian Funeral Rituals: Tradition, Modernity, Trends II*, 2019: 105-114.]
- Хүрэлсүх, С.** (2024). *Хадны оршуулга: Монголын эртний оршуулгын өвөрмөц хэлбэр*. Улаанбаатар: Мөнхийн үсэг. [Khürelsükh, S. *Khadnii orshuulga: Mongoliin ernii orshuulgin övörmöts khelber* [Rock Burial: A Special Type of Burial of the Ancient Mongols]. Ulaanbaatar: Mönkhiin üseg, 2024.]
- Цэрэндагва, Ч.** (2019). Чулуун зэвсгийн үеийн оршуулгын зан үйлийн асуудалд. *Монголчуудын хойлгын зан үйл: уламжлал-орчин үе-чиг хандлага эрдэм шинжилгээний II хурлын материал*. 11-23. [Tserendagva, Ch. Burial Practices and Rituals in the Stone Age. *Proceeding of Mongolian Funeral Rituals: Tradition, Modernity, Trends II*, 2019: 11-23.]
- Эрдэнэбат, У., Эрэгзэн, Г.** (2001). Баянхонгор аймгийн нутагт шинээр олдсон агуйн оршуулга. *Музей судлал*. Tomus I (IV), Fasc. 28: 25-30. [Erdenebat, U., Eregzen, G. A Newly Discovered Cave Burial in Bayankhongor Province. *Museum Studies*. 2001, Tomus I (IV), Fasc. 28: 25-30.]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>